



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.02.26 № 11/1006
танай _____-ны № _____-т

Санал авах тухай

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал авахаар хүргүүлэв.

Хуулийн төслийг судлан үзэж, саналаа ирүүлнэ үү.

Хавсралт:

1. Үзэл баримтлал;
2. Товч танилцуулга;
3. Дэлгэрэнгүй танилцуулга;
4. Хуулийн төсөл;
5. Дагалдуулан боловсруулсан хуулийн төслүүд.
6. Холбогдох судалгааг агуулсан QR код.

 Б.ЭНХБАЯР

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД

Б.ЭНХБАЯР

**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

2026 оны ...дугаар сарын ...-ны өдөр

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй..." гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж тус тус заасан.

Түүнчлэн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2.7-д "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх, иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл, компани, шударга өрсөлдөөн, монополь, хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно" гэж заасан.

Мөн Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 37-д "Шүүх хуралдааны өмнөх шатанд шүүхийн урьдчилан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой зохицуулалтыг нарийвчлах, оновчтой механизмыг бүрдүүлэх, үндэслэл, журмыг тодорхойлох, арилжаа эрхлэгчид хоорондын маргаан шийдвэрлэх болон бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх процессыг хөнгөвчлөх, олон улсын чиг хандлагад нийцүүлэн цахим орчинд хийгдсэн гэрээ, хэлцлийг шүүхэд нотлох баримтаар тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэх, иргэн болон захиргааны хэргийн шүүхийн хэрэг, маргааны харьяаллын давхардлыг арилгах, иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг шүүх хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, боловсронгуй болгох" зорилтыг дэвшүүлсэн.

1.2.Практик хэрэгцээ, шаардлага

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2024 оны хуулиар Долдугаар¹ бүлэг буюу "Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа"-ны зохицуулалтыг шинээр тусгаж, уг зохицуулалтыг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн.

Үүний дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх байгуулагдаж, иргэний хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Гэвч хууль хэрэгжиж эхэлснээс хойш практикт тодорхой хүндрэл, асуудал үүсэж байгаа талаар хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланд¹ дурдсан бөгөөд дараах асуудлууд тулгамдаж байгааг онцолжээ. Үүнд:

1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд Долдугаар¹ дугаар бүлэг нэмсэн нэмэлт, өөрчлөлтийн төслийн танилцуулгаас үзэхэд, бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн шаардлагад тохирсон хэрэг хянан шийдвэрлэх үр дүнтэй боловч хялбар журмыг тусгасан бөгөөд энэхүү ажиллагаа гагцхүү мөнгөн дүнд хязгаарлагдсан мөнгөн хөрөнгө гаргуулах нэхэмжлэлийн шаардлагад үйлчилнэ. Энэхүү мөнгөн хөрөнгийн дүнг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр тогтоож, 6 төрлийн нэхэмжлэлийн шаардлагыг тодорхойлсон. Мөнгөн хөрөнгийн хэмжээ нь 2023 оны байдлаар 11,000,000 төгрөг ($550,000 \times 20$)-тэй тэнцэнэ гэж тусгажээ.

2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоолоор тус шүүхэд Эрүү, Иргэний танхим байгуулсан. Үүний дагуу Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн тогтоолоор Эрүү, Иргэний танхим тус бүр 20 шүүгчийн бүрэлдэхүүнтэй байхаар шийдвэрлэсэн байна.

Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн мэдээлснээр 2025 оны байдлаар тус шүүх нийт 51,038 нэхэмжлэл, хэргийг хүлээн авч, 28,611 хэргийг шийдвэрлэсэн байна. Үүнээс 9,978 хэргийг хэрэгсэхгүй болгож, 2,684 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзжээ.

Харин 2026 оны хоёрдугаар сарын байдлаар 8,412 нэхэмжлэл шинээр хүлээн авч, 3,376 хэргийг шийдвэрлэсэн бөгөөд 3,065 хэргийг хэрэгсэхгүй болгож, 253 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна. Одоогийн байдлаар нийт 21,116 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байна.

Тус шүүх нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй буюу 792,000 төгрөгийг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээ болох 15,840,000 төгрөгөөс доош үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах иргэний хэргийг шийдвэрлэдэг бөгөөд 2025.04.01-ний өдөр нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 660,000 төгрөгөөс 792,000 төгрөг болгосноос нэг шүүгчид ногдох хэргийн тоо дундажаар 2.5 дахин өссөн. Тодруулбал, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 660,000 төгрөг байх үед нэг шүүгчид 619 хэрэг ногдож байсан бол уг хэмжээ 792,000 төгрөг болж нэмэгдсэнээр, 1456 хэрэгт хүрч, нэг улиралд нэг шүүгчид ногдох хэргийн тоо үлэмж өссөн үзүүлэлттэй байна.

Дээрх статистик үзүүлэлтээс харахад, нэг шүүгчид дунджаар 1,456 хэрэг, нэхэмжлэл оногдож байгаа нь шүүхийн ачаалал өндөр түвшинд байгааг илтгэж

¹ Норовсамбуу.Н., Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн "Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа"-ны зохицуулалтад хийсэн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээний тайлан. Улаанбаатар., 2026 он.

байна. Гэвч Иргэний хэргийн танхимын хувьд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс нэг шүүгчид ногдох зохист ачааллыг 336 хэрэг байхаар тогтоосон байдаг.

Бусад улсын жишгийг авч үзвэл, бага үнийн дүнтэй маргааныг хурдан шуурхай шийдвэрлэх тусгай хэрэг хянан шийдвэрлэх процессыг бий болгосон байх явдал нийтлэг бөгөөд ихэвчлэн мөнгөн төлбөрийн үүргийг шаардаж буй нэхэмжлэлд тодорхой үнийн дүнгийн дээд хязгаар тавигддаг.

№	Улс, орнууд	Бага үнийн дүнтэй хэргийн шалгуур
1	Европын холбоо	5,000 евро хүртэл ²
2	Англи	10,000 фунтээс хэтрэхгүй байх ³
3	Япон	1,400,000 иен хүртэл ⁴
4	Солонгос	30,000,000 воноос хэтрэхгүй байх ⁵
5	ХБНГУ	600 евро.

Иймд цаашид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэх тутам нэг шүүгчид оногдох нэхэмжлэл, хэрэг нэмэгдэж, тус шүүхийн ачаалал улам ихсэхээс сэргийлж, тогтмол үнийн дүнг олон улсын жишгээр хуульчлах шаардлага үүссэн байна.

Мөн тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт нийцэхгүй зарим хэргийн харьяаллыг хасах шаардлага үүссэн. Тухайлбал, хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах, шинжээчийн дүгнэлтийн талаар маргаантай бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн хөрөнгө гаргуулах нэхэмжлэл. Эдгээр нь тооцоолол, судалгаа хийх, шинжээч томилох зэрэг нэмэлт ажиллагаа хийхийг шаарддаг тул богино хугацаанд шуурхай шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн болно.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75⁴ дүгээр зүйлийн 75^{4.1} дэх хэсэгт “Мэдэгдэх хуудсыг баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлсэн боловч ...” гэж заасан боловч тус шуудангаар хүргүүлэх үйл ажиллагаа нь үр нөлөө багатай байна.⁶ Тодруулбал, Монгол шуудангаар мэдэгдэх хуудас хүргүүлэхэд жилд 300 сая орчим төгрөгийн зардал гарч байгаа боловч 85 орчим хувьд нь мэдэгдэх хуудас гардуулалт амжилтгүй болж байна. Харин шүүх бичиг хүргэгчээр хүргүүлэхэд гардуулан өгсөн гүйцэтгэл 85 орчим хувьтай байна. Гэхдээ 6 дүүргийн хэмжээнд тус бүр 1 бичиг хүргэгч ногдож байгаа нь хангалтгүй байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75⁴ дүгээр зүйлийн 75^{4.2} дахь хэсэгт энэ хуулийн 75^{4.1}-д заасны дагуу улсын бүртгэлийн байгууллагаас тодруулж ирүүлсэн хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол иргэн, хуулийн этгээдтэй төрийн байгууллагаас харилцах төрийн мэдээллийн нэгдсэн системийн иргэний, эсхүл хуулийн этгээдийн хувьд түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар, өмгөөлөгчийн Монголын Өмгөөлөгчдийн холбооны цахим системд бүртгүүлж

² https://europa.eu/youreurope/business/dealing-with-customers/solving-disputes/european-small-claims-procedure/index_en.htm

³ <https://www.citizensadvice.org.uk/law-and-courts/legal-system/small-claims/making-a-small-claim/>

⁴ https://www.courts.go.jp/english/judicial_sys/qa_on_Summary_Court_Procedure/index.html

⁵ https://jifi.scourt.go.kr/foreigner/en/html/proceedings/civil/small_claims_cases.html

⁶ Норовсамбуу.Н., Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн “Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-ны зохицуулалтад хийсэн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээний тайлан. Улаанбаатар., 2026 он.

холбогдсон цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээнэ гэж заасан.

Гэвч Үндэсний цахим шуудангийн систем болох E-Mongolia системийн ажиллагаа тогтворгүй, практикт хэрэгжихгүй байгаа нь хүндрэл үүсгэж байна. Тодруулбал, тус системээр илгээсэн мэдэгдэх хуудас дийлэнх тохиолдолд хүлээн авагчид хүрэхгүй байх тул мэдэгдэх хуудсыг гардуулж чадахгүйд хүрээд байна.

Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх (Иргэний танхим)-ийн хэмжээнд 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар нийт 12396 хэрэг хянан шийдвэрлэгдэж байгаагаас 2024 онд үүссэн хэргийн үлдэгдэл 177 байх бол, 2025 онд үүссэн хэргийн үлдэгдэл 12219 байна. Нийт маргаан буюу 12396 хэрэгт судалгаа хийх явцад 8 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 561 хэргийг шийдвэрлэсэн байсан тул шийдвэрлэгдсэн хэргүүдийг хасаж үлдэх 11835 хэргийг маргааны төрлөөр нь ангилсан болно. Нийт 11835 хэргийг хянан шийдвэрлэсэн хуулиар нь ангилан үзвэл:

- Иргэний хуулиар 11076 маргаан;
- Хөдөлмөрийн тухай хуулиар 59 маргаан;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар 84 маргаан байна.

Судалгаанд хамрагдсан хугацаанд, тус шүүх нийт 12396 иргэний хэрэг хянан шийдвэрлэж байгаагаас, шийдвэрлэгдсэн хэргийг хасахад 11835 хэрэг үлдэгдэл, үүнээс 11076 нь Иргэний хуулиар шийдвэрлэгдэх хэрэг байжээ. Тодруулбал, үүний 9359 нь зээлийн гэрээний маргаан байна.

Тус шүүхэд хянан шийдвэрлэж буй маргааны дийлэнх хувийг эзэлж байгаа цахим зээлийн хэргүүдийн хувьд хариуцагч буюу зээлдэгчид мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийг гардуулан өгөхөд бодит хүндрэл үүсэж байна.

Тухайлбал, зээл авахдаа ихэнхдээ нэг л хаяг бүртгүүлдэг бөгөөд тухайн хаяг дээрээ оршин суудаггүй, хаяг тодорхойгүй байх тохиолдол түгээмэл байна. Зарим тохиолдолд өөрийн нэр дээр бус, бусдын нэр дээр зээл авсан байх зэрэг зөрчил илэрч байгаа нь зээл олголтын үеийн баталгаажуулалт хангалтгүй байгаатай холбоотой.

Ийнхүү зээлдэгчийн иргэний үнэмлэхийн мэдээлэл, оршин суугаа хаяг, холбоо барих мэдээллийн баталгаажуулалт дутуу хийгдсэнээс шүүхийн мэдэгдэх ажиллагаа удааширч, улмаар хэрэг хянан шийдвэрлэх хугацаа сунжрах, зарим тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгоход хүргэж байна.

Иймд иргэн, хуулийн этгээдтэй төрийн байгууллагаас харилцах төрийн мэдээллийн нэгдсэн системийн иргэний, эсхүл хуулийн этгээдийн хувьд түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээснээс хойш тодорхой хугацаа өнгөрсөн ч шүүхэд ирээгүй бол мэдэгдэх хуудсыг мэдэгдсэн талаар олон нийтэд нээлттэй зарлаж, мэдэгдсэнд тооцох зохицуулалтыг бий болгох, нөгөөтэйгүүр цахим зээл олгоход хаягийн баталгаажуулалтыг сайжруулж, хуульчлах шаардлага үүссэн.

Мөн ердийн журмаар шийдвэрлэх хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргахад хэргийг хэрэгсэхгүй болгохгүй байх, иргэний хэрэг үүсгэснээс хойш тийм нөхцөл байдал илэрвэл өөр шүүхэд шилжүүлэх зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага үүссэн.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр хуулийн төсөл боловсруулах бөгөөд дараах асуудлыг зохицуулна. Үүнд:

Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд шийдвэрлэх хэргийн мөнгөн дүнг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд суурилах бус тогтмол мөнгөн дүнг оновчтой хуульчилж, хялбар ажиллагааны онцлогт нийцсэн хэргийг шуурхай шийдвэрлэх, хэт их ачаалал үүсэхээс сэргийлсэн зохицуулалтыг бий болгоно;

Мөн тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт нийцэхгүй зарим хэргийн харьяаллыг хасна. Тухайлбал, хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах, шинжээчийн дүгнэлтийн талаар маргаантай бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн хөрөнгө гаргуулах нэхэмжлэл;

Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх хэргийн дийлэнх хувийг эзлэх цахим буюу финтек зээлийн маргааны хувьд шүүхийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан хэргийн оролцогчийн үндэсний цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн тухай нийтэд зарлаж, шүүхэд хүрэлцэн ирж эрхээ хамгаалахыг мэдэгдсэнээс хойш 7 хоногийн хугацаа өнгөрсөн тохиолдолд мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ;

Түүнчлэн дээрх төрлийн маргаанд зээлдэгчийг таних, баталгаажуулах ажиллагааг илүү нарийвчилж, хуульчилна. Ингэснээр шүүхэд хэрэг үүсгэх үед хариуцагчид мэдэгдэх хуудас гардуулахад үүсдэг хүндрэл, саатлыг бууруулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай, үр нөлөөтэй явуулах нөхцөлийг бүрдүүлнэ;

Мөн ердийн журмаар шийдвэрлэх хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргахад хэргийг хэрэгсэхгүй болгохгүй байх, иргэний хэрэг үүсгэснээс хойш тийм нөхцөл байдал илэрвэл өөр шүүхэд шилжүүлэх зохицуулалтыг боловсронгуй болгоно.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удаашрал багасаж, маргааныг хурдан, шуурхай, үр дүнтэй шийдвэрлэх нөхцөл бүрдэнэ.

Мөн шүүхийн албан ёсны цахим хуудсаар мэдэгдэх хуудас хүргүүлсэнд тооцох зохицуулалт бий болох нь тус ажиллагааг аль болох богино хугацаанд, хэргийн оролцогчдыг чирэгдүүлэхгүйгээр, шуурхай явуулах боломжийг бүрдүүлнэ.

Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх хэргийн нэхэмжлэлийн үнийн дүнг тогтмол дүнгээр тогтоосноор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэх бүрд шүүхийн харьяалах хэргийн тоо огцом нэмэгдэж, ачаалал өсөх эрсдэл буурна.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээтэй нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл тус тус боловруулна.

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

/Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар/

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсгийн 1 дэх заалтад Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийг байгуулахаар заасан.

2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоолоор тус шүүхэд Эрүү, Иргэний танхим байгуулсан. Үүний дагуу Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн тогтоолоор Эрүү, Иргэний танхим тус бүр 20 шүүгчийн бүрэлдэхүүнтэй байхаар шийдвэрлэсэн байна.

Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн мэдээлснээр 2025 оны байдлаар тус шүүх нийт 51,038 нэхэмжлэл, хэргийг хүлээн авч, 28,611 хэргийг шийдвэрлэсэн байна. Үүнээс 9,978 хэргийг хэрэгсэхгүй болгож, 2,684 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзжээ.

Харин 2026 оны хоёрдугаар сарын байдлаар 8,412 нэхэмжлэл шинээр хүлээн авч, 3,376 хэргийг шийдвэрлэсэн бөгөөд 3,065 хэргийг хэрэгсэхгүй болгож, 253 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна. Одоогийн байдлаар нийт 21,116 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байна.

Тус шүүх нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй буюу 792,000 төгрөгийг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээ болох 15,840,000 төгрөгөөс доош үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах иргэний хэргийг шийдвэрлэдэг бөгөөд 2025.04.01-ний өдөр нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 660,000 төгрөгөөс 792,000 төгрөг болгосноос нэг шүүгчид ногдох хэргийн тоо дундажаар 2.5 дахин өссөн. Тодруулбал, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 660,000 төгрөг байх үед нэг шүүгчид 619 хэрэг ногдож байсан бол уг хэмжээ 792,000 төгрөг болж нэмэгдсэнээр, 1456 хэрэгт хүрч, нэг улиралд нэг шүүгчид ногдох хэргийн тоо үлэмж өссөн үзүүлэлттэй байна.

Дээрх статистик үзүүлэлтээс харахад, нэг шүүгчид дунджаар 1,456 хэрэг, нэхэмжлэл оногдож байгаа нь шүүхийн ачаалал өндөр түвшинд байгааг илтгэж байна. Гэвч Иргэний хэргийн танхимын хувьд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс нэг шүүгчид ногдох зохист ачааллыг 336 хэрэг байхаар тогтоосон байдаг.

Иймд цаашид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэх тутам нэг шүүгчид оногдох нэхэмжлэл, хэрэг нэмэгдэж, тус шүүхийн ачаалал улам ихсэхээс сэргийлж, тогтмол үнийн дүнг олон улсын жишгээр хуульчлах шаардлагын хүрээнд тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх хэргийн хувьд арван таван сая найман зуучн дөчин мянган төгрөгөөс доошгүй мөнгөн дүнтэй хэргийг шийдвэрлэхээр хуулийн төсөлд тусгалаа. Мөн тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт

нийцэхгүй зарим хэргийн харьяаллыг хасав. Тухайлбал, хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах, шинжээчийн дүгнэлтийн талаар маргаантай бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн хөрөнгө гаргуулах нэхэмжлэл. Эдгээр нь тооцоолол, судалгаа хийх, шинжээч томилох зэрэг нэмэлт ажиллагаа хийхийг шаарддаг тул богино хугацаанд шуурхай шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн болно.

Түүнчлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75⁴ дүгээр зүйлийн 75^{4.1} дэх хэсэгт “Мэдэгдэх хуудсыг баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлсэн боловч ...” гэж заасан боловч тус шуудангаар хүргүүлэх үйл ажиллагаа нь үр нөлөө багатай байна.¹ Тодруулбал, Монгол шуудангаар мэдэгдэх хуудас хүргүүлэхэд жилд 300 сая орчим төгрөгийн зардал гарч байгаа боловч 85 орчим хувьд нь мэдэгдэх хуудас гардуулалт амжилтгүй болж байна. Харин шүүх бичиг хүргэгчээр хүргүүлэхэд гардуулан өгсөн гүйцэтгэл 85 орчим хувьтай байна. Гэхдээ 6 дүүргийн хэмжээнд тус бүр 1 бичиг хүргэгч ногдож байгаа нь хангалтгүй байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75⁴ дүгээр зүйлийн 75^{4.2} дахь хэсэгт энэ хуулийн 75^{4.1}-д заасны дагуу улсын бүртгэлийн байгууллагаас тодруулж ирүүлсэн хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол иргэн, хуулийн этгээдтэй төрийн байгууллагаас харилцах төрийн мэдээллийн нэгдсэн системийн иргэний, эсхүл хуулийн этгээдийн хувьд түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар, өмгөөлөгчийн Монголын Өмгөөлөгчдийн холбооны цахим системд бүртгүүлж холбогдсон цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээнэ гэж заасан.

Гэвч Үндэсний цахим шуудангийн систем болох E-Mongolia системийн ажиллагаа тогтворгүй, практикт хэрэгжихгүй байгаа нь хүндрэл үүсгэж байна. Тодруулбал, тус системээр илгээсэн мэдэгдэх хуудас дийлэнх тохиолдолд хүлээн авагчид хүрэхгүй байх тул мэдэгдэх хуудсыг гардуулж чадахгүйд хүрээд байна.

Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх (Иргэний танхим)-ийн хэмжээнд 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар нийт 12396 хэрэг хянан шийдвэрлэгдэж байгаагаас 2024 онд үүссэн хэргийн үлдэгдэл 177 байх бол, 2025 онд үүссэн хэргийн үлдэгдэл 12219 байна. Нийт маргаан буюу 12396 хэрэгт судалгаа хийх явцад 8 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 561 хэргийг шийдвэрлэсэн байсан тул шийдвэрлэгдсэн хэргүүдийг хасаж үлдэх 11835 хэргийг маргааны төрлөөр нь ангилсан болно. Нийт 11835 хэргийг хянан шийдвэрлэсэн хуулиар нь ангилан үзвэл:

- Иргэний хуулиар 11076 маргаан;
- Хөдөлмөрийн тухай хуулиар 59 маргаан;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар 84 маргаан байна.

Судалгаанд хамрагдсан хугацаанд, тус шүүх нийт 12396 иргэний хэрэг хянан шийдвэрлэж байгаагаас, шийдвэрлэгдсэн хэргийг хасахад 11835 хэрэг үлдэгдэл,

¹ Норовсамбуу.Н., Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн “Тусгайласан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-ны зохицуулалтад хийсэн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээний тайлан. Улаанбаатар., 2026 он.

үүнээс 11076 нь Иргэний хуулиар шийдвэрлэгдэх хэрэг байжээ. Тодруулбал, үүний 9359 нь буюу 80 хувь нь зээлийн гэрээний маргаан байна.

Тус шүүхэд хянан шийдвэрлэж буй маргааны дийлэнх хувийг эзэлж байгаа цахим зээлийн хэргүүдийн хувьд хариуцагч буюу зээлдэгчид мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийг гардуулан өгөхөд бодит хүндрэл үүсэж байна.

Тухайлбал, зээл авахдаа ихэнхдээ нэг л хаяг бүртгүүлдэг бөгөөд тухайн хаяг дээрээ оршин суудаггүй, хаяг тодорхойгүй байх тохиолдол түгээмэл байна. Зарим тохиолдолд өөрийн нэр дээр бус, бусдын нэр дээр зээл авсан байх зэрэг зөрчил илэрч байгаа нь зээл олголтын үеийн баталгаажуулалт хангалтгүй байгаатай холбоотой.

Ийнхүү зээлдэгчийн иргэний үнэмлэхийн мэдээлэл, оршин суугаа хаяг, холбоо барих мэдээллийн баталгаажуулалт дутуу хийгдсэнээс шүүхийн мэдэгдэх ажиллагаа удааширч, улмаар хэрэг хянан шийдвэрлэх хугацаа сунжрах, зарим тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгоход хүргэж байна.

Иймд иргэн, хуулийн этгээдтэй төрийн байгууллагаас харилцах төрийн мэдээллийн нэгдсэн системийн иргэний, эсхүл хуулийн этгээдийн хувьд түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээснээс хойш тодорхой хугацаа өнгөрсөн ч шүүхэд ирээгүй бол мэдэгдэх хуудсыг мэдэгдсэн талаар олон нийтэд нээлттэй зарлаж, мэдэгдсэнд тооцох зохицуулалтыг бий болгож, нөгөөтэйгүүр цахим зээл олгоход хаягийн баталгаажуулалтыг сайжруулж, холбогдох зохицуулалтыг тусгалаа.

Мөн ердийн журмаар шийдвэрлэх хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргахад хэргийг хэрэгсэхгүй болгохгүй байх, иргэний хэрэг үүсгэснээс хойш тийм нөхцөл байдал илэрвэл өөр шүүхэд шилжүүлэх зохицуулалтыг боловсронгуй болголоо.

—000—

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

/Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар/

Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4-т хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад холбогдох тайлбарыг шинэчилсэн найруулга бол бүлгээр, нэмэлт, өөрчлөлт бол зүйл, эсхүл хэсэг, заалт тус бүрээр багцлан тусгахаар заасны дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт бүрээр багцлан дэлгэрэнгүй тайлбарыг дараах байдлаар хийлээ. Үүнд:

1.Хэргийг ердийн шүүхэд шилжүүлэх зохицуулалтын талаар:

Хуулийн 75⁷ дугаар зүйлийн 75⁷.1-д зааснаар шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш дараах нөхцөл байдал тогтоогдвол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай захирамж гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ:

-75⁷.1.1.нэхэмжлэл гаргах, эсхүл иргэний хэрэг үүсгэхдээ энэ хуулийн 75¹ дүгээр зүйлд заасныг зөрчсөн;

-75⁷.1.2.тухайн хэрэг нь эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой байж болзошгүй гэж үзсэн.

Эдгээр тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй байхаар заасан.

Нэхэмжлэл гаргах, эсхүл иргэний хэрэг үүсгэхдээ энэ хуулийн 75¹ дүгээр зүйлд заасныг зөрчсөн, тухайн хэрэг нь эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай захирамж гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэхээр зохицуулсныг ердийн журмаар шийдвэрлүүлэх хэргийг ердийн шүүхэд нь шилжүүлж шийдвэрлүүлэхээр өөрчлөлт орууллаа.

Учир нь хуулийн 75⁷ дугаар зүйл хэргийг өөр шүүхэд шилжүүлэх талаарх 20 дугаар зүйлтэй уялдаагүйгээр зохицуулснаас улбаалан мөн зүйлийн 75⁷.4-т хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхээр үргэлжлүүлэх нь тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх, ингэснээр тус шүүх шуурхай ажиллах зорилготой нийцэхгүй байдал үүссэн.

Түүнчлэн 75⁷ дугаар зүйлийн 75⁷.1-д заасан тохиолдол үүссэн бол хэргийг өөр шүүхэд шилжүүлэхэд хэргийг хүлээн авсан шүүх хэрэг хянан шийдвэрлэх хугацааг шинээр тоолохгүй, үргэлжлүүлэн ердийн журмаар шийдвэрлэхээр тусгаснаар иргэдэд нэг асуудлаар дахин хугацаа тоолж, ажиллагаа удаашрах нөхцөл үүсэхээс сэргийлсэн зохицуулалтыг бий болголоо.

Хуулийн 117 дугаар зүйлийн 117.1-д “Энэ хуулийн 75⁷.1.1-д зааснаас бусад тохиолдолд” гэж нэмсэнээр хариуцагчийн хаяг тодорхойгүй гэх үндэслэл иргэний хэрэг үүсгэснээс хойш тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгохдоо нэгэнт иргэний

хэрэг үүсгэхдээ хуулийн 75¹ дүгээр зүйлд заасныг зөрчсөн бол хэргийг хэрэгсэхгүй болгох бус, хэргийг ердийн шүүхэд шилжүүлэх үндэслэл бүрдэнэ.

Мөн энэхүү зохицуулалтаар нэхэмжлэл гаргахад хуулийн 75¹ дүгээр зүйлд заасныг зөрчсөн бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай захирамж гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх үр дагавартай байгаа нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан харьяаллын бус нэхэмжлэл гаргахад нэхэмжлэлийг буцаах зохицуулалттай нийцэхгүй байх тул 75⁷.1.1-д "нэхэмжлэл гаргах, эсхүл иргэний хэрэг үүсгэхдээ энэ хуулийн 75¹ дүгээр зүйлд заасныг зөрчсөн" гэсний "нэхэмжлэл гаргах, эсхүл" гэснийг хасав.

Ингэснээр нэгэнт тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх хэргийн харьяалал зөрчсөн нэхэмжлэлийг хэрэг үүсгэхгүйгээр хүлээн авахаас татгалзах, улмаар нэхэмжлэгч уг асуудлаар ердийн шүүхэд цаг алдалгүй хандах боломж бүрдэнэ.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75¹ дүгээр зүйлийн 75¹.1 дэх хэсэгт заасан тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд харьяалан шийдвэрлэх хэргийн талаар оруулсан өөрчлөлтийн тухайд:

Хуулийн 75¹ дүгээр зүйлийн 75¹.1-д "Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах дараах нэхэмжлэлийг шүүгч дангаар тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:" гэж заасныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд суурилахгүйгээр, тогтмол мөнгөн дүнг тусгах байдлаар шүүх бага үнийн дүнтэй хэргийг шуурхай шийдвэрлэх нөхцөлийг хангах нөхцөлийг бүрдүүлсэн.

Түүнчлэн мөн зүйлийн 75¹.2-т нэхэмжлэлийг үнийн дүнгээс үл хамааран шүүх тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх хэргийн төрөлд гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах нэхэмжлэл хамаарахаар заасныг үнийн дүнд хамааруулах буюу арван таван сая найман зуун дөчин мянган төгрөгнөөс доош үнийн дүн бүхий үндсэн үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах байдлаар өөрчилсөн бөгөөд ингэснээр их хэмжээний үнийн дүн бүхий гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах нэхэмжлэлийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэхгүй болно.

Мөн зүйлийн 75¹.1.3-д зааснаар хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах нэхэмжлэлийг тусгайлсан журмаар шийдвэрлэх зохицуулалтыг хүчингүй болголоо. Учир нь энэ төрлийн нэхэмжлэл нь шүүгчээс бодолт, тооцоолол хийх зэргээр ердийн журмаар хянан шийдвэрлэх нөхцөлийг шаарддаг.

3.Мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцох зохицуулалтын талаар:

Хуулийн 75⁴ дүгээр зүйлийн 75⁴.4-т цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээснээс хойш 7 хоног өнгөрсөн боловч шүүхэд ирээгүй бол шүүхийн албан ёсны цахим хуудсаар нэхэмжлэгч, хариуцагчийн нэр, овог, нэхэмжлэлийн шаардлага болон хувийн ба үндэсний цахим шуудангийн хаягаар нь мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн тухай дурдан, шүүхэд хүрэлцэн ирж эрхээ хамгаалахаар ажиллагаанд оролцохыг зарлан мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдсэнээс хойш 7 хоног өнгөрсөн бол мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцож хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулахаар тусгаж, ажиллагаа удаашрахаас сэргийлсэн зохицуулалтыг бий болголоо.

Ийнхүү шүүх албан ёсны цахим хуудсаар зарлан мэдэгдсэнийг хүний нэр төр, алдар хүндийг гутаах, дормжлох, гүтгэх болон хувь хүний эрхэмсэг оршихуйд сөрөг нөлөөлөхүйц байдлаар ашиглах, ийм зорилгоор хуваалцан, нийтэд мэдээлэхийг хориглох байдлаар тусгав.

Хуулийн 75⁴ дүгээр зүйлийн 75⁴ дүгээр зүйлийн 75⁴.1, 75⁴.2, 75⁴. дахь хэсгийг хэрэгжүүлсний дараа 75⁴.4 дэх хэсэгт заасан хүлээн авсанд тооцох зохицуулалтыг хэрэглэнэ.

—000—

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулга бүхий хэсэг, заалт нэмсүгэй:

1/20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалт:

“20.1.4.энэ хуулийн 75⁷.1-д заасан үндэслэл тогтоогдсон бол.”

2/75¹ дүгээр зүйлийн 75¹.1.5 дахь заалт:

“75¹.1.5.үндсэн үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах.”

3/75¹ дүгээр зүйлийн 75¹.6 дахь хэсэг:

“75¹.6.Нэхэмжлэлийн шаардлагаа энэ хуулийн 75¹.1-д заасан гэрээний үндэслэлээр тодорхойлсныг гэрээнээс татгалзсан, эсхүл хэлцэл хүчин төгөлдөр бус гэх үндэслэлээр эсэргүүцэн маргасан нь тус хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэхэд саад болохгүй.”

4/75⁴ дүгээр зүйлийн 75⁴.5 дахь хэсэг:

“75⁴.5.Энэ хуулийн 75⁴.4-т заасан шүүхийн цахим хуудасны мэдээллийг хүний нэр төр, алдар хүндийг гутаах, дормжлох, гүтгэх болон хувь хүний эрхэмсэг оршихуйд сөрөг нөлөөлөхүйц байдлаар ашиглах, ийм зорилгоор хуваалцах, нийтэд мэдээлэхийг хориглоно.”

5/75⁴ дүгээр зүйлийн 75⁴.6 дахь хэсэг:

“75⁴.6.Финтек зээлийн бүтээгдэхүүний талаарх нэхэмжлэлийн хувьд энэ хуулийн 75⁴.2, 75⁴.3-т заасны дагуу цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээснээс хойш 7 хоног өнгөрсөн боловч шүүхэд ирээгүй бол шүүхийн албан ёсны цахим хуудсаар нэхэмжлэгч, хариуцагчийн нэр, овог, нэхэмжлэлийн шаардлага болон хувийн ба үндэсний цахим шуудангийн хаягаар нь мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн тухай дурдан, шүүхэд хүрэлцэн ирж эрхээ хамгаалахаар ажиллагаанд оролцохыг зарлан мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдсэнээс хойш 7 хоног өнгөрсөн бол

мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцож хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулна.”

2 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75¹ дүгээр зүйлийн 75^{1.1.2} дахь заалтын “дундын өмчийн ашиглалт” гэсний өмнө “Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.1-д заасан” гэж, 75¹ дүгээр зүйлийн 75^{1.1.4} дэх заалтын “бусдын эд хөрөнгө” гэсний өмнө “шинжээчийн дүгнэлтийн талаар маргаангүй бол” гэж, 117 дугаар зүйлийн 117.1 дэх хэсгийн “Энэ хуулийн” гэсний дараа “75^{7.1.1}-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75¹ дүгээр зүйлийн 75^{1.1} дэх хэсгийн “Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс” гэснийг “Арван таван сая найман зуун дөчин мянган төгрөгөөс” гэж, 75⁷ дугаар зүйлийн 75^{7.1} дэх хэсгийн “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ.” гэснийг “энэ хуулийн 20.1.4-т заасны дагуу өөр шүүхэд шилжүүлж болно.” гэж, 75⁷ дугаар зүйлийн 75^{7.3} дахь хэсгийн “байна.” гэснийг “байх боловч шилжүүлсэн хэргийг хүлээн авсан шүүх шаардлагатай гэж үзвэл товыг өөрчлөн тогтоож болно. Тов өөрчилсөн шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй.” гэж, 75⁷ дугаар зүйлийн 75^{7.4} дэх хэсгийн “Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхээр үргэлжлүүлсэн нь” гэснийг “Хэргийг өөр шүүхэд шилжүүлсэн нь” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75⁴ дүгээр зүйлийн гарчигийн “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэл”, 75⁷ дугаар зүйлийн 75^{7.1.1} дэх заалтын “нэхэмжлэл гаргах, эсхүл” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75¹ дүгээр зүйлийн 75^{1.1.3}, 75^{1.2.2} дахь заалт, 75⁷ дугаар зүйлийн 75^{7.2} дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАНК, ЭРХ БҮХИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МӨНГӨН ХАДГАЛАМЖ, МӨНГӨН ХӨРӨНГИЙН ШИЛЖҮҮЛЭГ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 20.9, 20.10 дахь хэсэг тус тус нэмсүгэй:

“20.9.Зээлдүүлэгч нь зээлдэгчийн оршин суугаа хаяг болон хувийн болон үндэсний цахим шуудангийн хаягийг баталгаажуулсны үндсэн дээр финтек зээлийн гэрээ байгуулна.

20.10.Зээлдүүлэгч нь финтек зээлийн гэрээтэй холбоотой нэхэмжлэлийг шүүхэд гаргах тохиолдолд энэ хуулийн 20.9-д заасан хаягийн баталгаажуулалтын баримтыг шүүхэд нотлох баримтаар ирүүлэх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргийг биелүүлээгүй бол шүүх тухайн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл болно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.1 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 8 дахь хэсэг нэмсүгэй:

“8.Энэ хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх тухай хүсэлт гаргахад сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн төлсөн, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн нь хамаарахгүй.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болж дагаж мөрдөхөөс өмнө Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75¹ дүгээр зүйлд заасны дагуу үүсгэсэн хэрэг, хүлээн авсан нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө уг харилцааг зохицуулж байсан хуулиар хянан шийдвэрлэх бөгөөд нэхэмжлэлийг хүлээн авсан, иргэний хэрэг үүсгэсэн тухайн шүүх хэргийг анхан шатны журмаар, тус шүүхийг харьяалах давж заалдах шатны шүүх давж заалдах журмаар тус тус хянан шийдвэрлэнэ.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

1. Хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ



2. Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ



3. Хуулийн төслийн зардлын тооцоо

